



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/39

Баян-Өндөр сум

Үйл ажиллагаа зохион байгуулж,
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1 дах заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2026 оны төсөв батлах тухай” 02/58 дугаар тогтоол, Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 17-ний “Хөрөнгө гаргах тухай” А/245 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих сарын аяны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардлагатай төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аяны үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн (А.Хонгорзул)-д даалгасугай.

3. Шаардагдах 3,500,000 (Гурван сая таван зуун мянган) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Г.Отгонцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (П.Хишгээ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ



**Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих сарын аян
зохион байгуулах удирдамж**

Үндэслэл: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 10-19 насныг "Өсвөр нас" гэж тодорхойлсон байдаг. Орхон аймагт 2024 оны байдлаар 10-19 насны 19,317 хүүхэд буюу нийт хүн амын 18%-ийг эзэлж байна. Өсвөр насны хүүхдийн эрүүл амьдралын дадал зуршил, хооллолт, сэтгэлзүйн эрүүл мэндийн чиглэлээр улсын хэмжээнд хийгдсэн судалгаануудад анхаарал татахуйц үр дүнгүүд гарсаар байгаа нь өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл дадал хэвшлийг дэмжих олон талт үйл ажиллагааг явуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Тухайлбал 2023 оны ДЭМБ-ын хийсэн сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаагаар ЕБС-ын 13-17 насны суралцагчдын 24.8 хувь буюу 4 суралцагч тутмын 1 нь сүүлийн 1 сард электрон тамхи хэрэглэсэн, 10 суралцагч тутмын 1 нь янжуур тамхи татсан гэх үр дүн гарчээ. Мөн уг судалгаанд хамрагдсан 51 сургуулийн 3351 хүүхдийн 30.5% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 9% нь сэтгэцийн эмгэгтэй байв.

Хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар (2023-2024) сургуулийн насны хүүхдийн 20% нь илүүдэл жинтэй, 90% нь Д аминдэмийн дутагдалтай, 42.2% нь эрүүл бус хоол хүнс хэрэглэдэг, 36.7% нь чихэрлэг ундаа тогтмол хэрэглэдэг, 28% нь огт хөдөлгөөн хийдэггүй байна. Хөдөлгөөн багатай, эрүүл бус хооллолт нь ирээдүйд зүрх судасны өвчин, чихрийн шижин үүсэх эрсдэлийг 8-10% хүртэл нэмэгдүүлж байна. Өсвөр насныхны хоол тэжээл болон хөдөлгөөний хэв маяг буюу таргалалт, шим тэжээлийн дутагдал зэрэгцэн оршиж Монголын хүүхдийн эрүүл мэндийн гол сорилт болж байна.

2024 онд МУ-ын хэмжээнд 15-19 насныхны дунд амиа хорлолтын 524 тохиолдол бүртгэгдсэн. Өсвөр үе, залуучуудын дунд амиа хорлолт нас баралтын шалтгаанд тэргүүлж байгаа төдийгүй дийлэнх нь эрэгтэйчүүд (81.3%) байна.

2025 оны байдлаар Орхон аймагт 10-19 насны хүүхдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, арьс ба халимны өвчин, шээс бэлгэсийн тогтолцооны өвчлөл, нүд ба дайврын өвчлөл тэргүүлж байна. Манай аймагт 15-19 насны хүүхдүүдийн дунд бэлгийн замаар дамжих халдварт өвчний 37 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 11 тохиолдлоор нэмэгдсэн. Охидын төрөлтийн 76 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор нэмэгдсэн. Үүнээс харьяаллын буюу Орхон аймгийн 61 (80.3%) охин байна. Охидын үр хөндөлтийн 30 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18 тохиолдлоор нэмэгдсэн. Үүнээс харьяаллын – 20 (66.6%) байна.

Өсвөр нас нь бие бялдар, сэтгэл зүй, зан үйл идэвхтэй төлөвшдөг, насанд хүрэгчдийн эрүүл мэндийн суурь тавигддаг чухал үе шат тул энэ насны хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлт зан үйлээс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал хэвшүүлэх чиглэлээр цогц арга хэмжээг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Зорилго:

1. Өсвөр насны хүүхдүүдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг эрт илрүүлэх, хяналтад авах.

2. Өсвөр үеийн хүүхдүүдийн дунд эрүүл хэв маягийг хэвшүүлэх, нөхөн үржихүй, халдварт өвчний талаарх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.
3. Үе тэнгийн сургагч багшийг бэлтгэх замаар хүүхдүүдэд эерэг нөлөөллийн хүрээг бий болгох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замд сургах.

Зохион байгуулагч: Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

Хамрах хүрээ: Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн Оношилгоо, эмчилгээний төв, төр болон хувийн хэвшлийн байгууллагууд, Ерөнхий боловсролын сургуулиуд, өсвөр насны хүүхдүүд

Хугацаа: 2026 оны 04-р сарын 06-аас 2026 оны 05-р сарын 22

Зохион байгуулагдах үйл ажиллагаа:

№	Хийгдэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
Нэг. Өсвөр насны хүүхдүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх			
1	Өсвөр насны эрүүл мэндийн чиглэлээр хийгдэж буй бодлогын баримт бичиг, тушаал шийдвэрийг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд таниулах, чадавхжуулах сургалт зохион байгуулах, хэрэгжилтийг үнэлэх.	2026.04.06 – 2026.04.30	ЭМГ, ЭМГ, СӨЭМТ, БОЭТ
2	Өсвөр насны хүүхдийн бүртгэл судалгааг сайжруулж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах.	2026.04.06 – 2026.05.22	ЭМГ, СӨЭМТ, БОЭТ
3	2025 онд төрсөн, үр хөндүүлсэн өсвөр насны охидын эргэн хяналтыг зохион байгуулах.	2026.04.06 – 2026.05.22	ХГБХГ, ЭМГ, СӨЭМТ
4	Гэмт хэрэгт холбогдсон болон гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийг эрүүл мэндийг үзлэг шинжилгээнд хамруулах.	Сар бүр	ХГБХГ, ЭМГ, БОЭТ, СӨЭМТ
Хоёр. Өсвөр насны хүүхдүүдэд эрүүл дадал хэвшлийг хөгжүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах			
1	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд хуваарилагдсан сургуулиуд дээр очиж өсвөр насны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах (Нөхөн үржихүй, сүрьеэ, БЗДХ-ын талаар) сургалт, өдөрлөг зохион байгуулах.	2026.04.06 – 2026.05.02	ЭМГ, БГ, ЕБС-ууд, СӨЭМТ
2	Нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлт, стресс менежментийн чиглэлээр үе тэнгийн сургагч багш бэлтгэх.	2026.04.17	ХГБХГ, ЭМГ, БГ, БОЭТ
3	Өсвөр насны хүүхдүүдийн дунд эрүүл дадал хэвшлийг хэвшүүлэх болзолт уралдаан зарлах.	2026.04.06 – 2026.05.02	ЭМГ, БГ, ЕБС-ууд, СӨЭМТ
4	Өсвөр үеийнхэн болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан зөвлөмж, зөвлөгөөг цахим хуудсаар байршуулж олон нийтэд түгээх.	2026.04.06 – 2026.05.22	СӨЭМТ, ЕБС-ууд

Хүлээгдэж буй үр дүн:

1. Өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна.
2. Өсвөр насныханд тулгамдаж буй эрүүл мэндийн өвөрмөц асуудлуудын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт сайжирсан байна.
3. Өсвөр үеийнхэн болон тэдний эцэг, эх асран хамгаалагчдын эрүүл мэндийн боловсрол сайжирсан байна.
4. Салбар дундын хамтын ажиллагаа сайжирсан байна.

Боловсруулсан: *А. Хонгорзул* ЭТҮХ-ийн мэргэжилтэн А.Хонгорзул

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны 11 сарын 25-ний өдрийн
1/39 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Төсвийн задаргаа

№	Үйл ажиллагаа	Тоо /Ширхэг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт /төгрөг/
1. Үе тэнгийн сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн төсөв				
1	Сургагч багшийн хөлс /Гарын авлага бэлтгэх/	3	100,000	300,000
2	Сургалтад суралцагсдын өдрийн хоол, цайны зардал	30	30,000	900,000
3	Сургалтын хэрэгсэл, бичгийн цаас, маркер бэлтгэх, гарын авлага хэвлэх	-	-	300,000
Нийт				1,500,000
2. Зөв үлгэр дуурайлал нөлөөллийн видео контентын уралдааны төсөв				
1	1-р байрын шагналын мөнгө	1	500,000	500,000
2	2-р байрны шагналын мөнгө	1	400,000	400,000
3	3-р байрны шагналын мөнгө	1	300,000	300,000
4	Тусгай байрны шагналын мөнгө	2	200,000	400,000
5	Өргөмжлөл	5	60,000	300,000
6	Бичиг хэргийн зардал	1	100,000	100,000
Нийт				2,000,000
БҮГД				3,500,000

Төсөв боловсруулсан: *А.Хонгорзул* ЭТҮХ-ийн мэргэжилтэн А.Хонгорзул